

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар
2025 оны эхний хагас жил

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Зүйл, заалтын агуулга	Хэрэгжилтын тайлан	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжээгүй шалтгаан	Хяналтаас хасах үндэслэл
ЗГ-ын тогтоол							
	215		4. 4. Аймаг, нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр богино, дунд, урт хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга С.Одонтуяа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журмын төслийг боловсруулан, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2025 оны 03 сарын 24-ний өдөр хэлэлцүүлж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025.04.23-ний өдрийн 01/1937 дугаартай журмын төсөлд санал хүргүүлэх тухай албан бичгийн дагуу Журмын төслийн 2.1.1, 2.1.9, 3.1.2, 3.1.4 зэрэг заалтад тус тус саналыг тусган хамтарсан тушаал, захирамжийг баталгаажуулахаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2025 оны 05 сарын 22-ны өдөр 01/3332 тоот албан бичгээр хүргүүлсэн болно. Мөн Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоохдоо засаг захиргааны анхан шатны нэгжээр ангилан "шар", "ногоон" бүсэд хуваасан. Агаарын чанарыг сайжруулах "шар" бүсэд 67,765 өрх багтсан. "Ногоон" бүсэд 103,090 өрхийг хамруулсан ба 2028 он хүртэл агаар	Хэрэгжсэн	-	-

				бохирдуулагч эх үүсвэрийн тоог бууруулж, цахилгаан, бүх төрлийн хий, сэргээгдэх эрчим хүч болон бусад эх үүсвэрт үе шаттайгаар шилжүүлэх, үүнээс 2025-2026 онд хийн түлшинд 33794 өрх, цахилгаан халаагуурт 17286 нийт 51080 өрхийг хий болон цахилгаан халаагуурт шилжүүлэхээр бэлтгэж байна.			
123	236	Журамд өөрчлөлт оруулах тухай 2025-02-26 Дугаар 2025_115	2.3. 2.3. агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр өвлийн улиралд гэр хорооллын айл өрхийн халаалтыг бүх төрлийн хийн түлш болон бусад дэвшилтэт шинэ технологи ашиглан шийдвэрлэх хувилбарыг судлан тодорхойлж, зарим байршилд хэрэглээнд нэвтрүүлж, үр дүнг тооцсоны үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх санал, дүгнэлтийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд 2025 оны II улиралд багтаан танилцуулахыг Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;	Агаарын чанарыг сайжруулах ногоон бүсэд хамрагдах 103090 өрхийг 2025-2028 онд бүх төрлийн хий, цахилгаан, сэргээгдэх эрчим хүч, бусад эх үүсвэрт үе шаттайгаар шилжүүлэх, үүнээс 2025-2026 онд хийн түлшинд 33794 өрх, цахилгаан халаагуурт 17286 нийт 51080 өрхийг хий болон цахилгаан халаагуурт шилжүүлэхээр бэлтгэж байна. Ногоон бүсэд байрлалтай СХД, БЗД, ЧД, СБД, БГД нийт 5 дүүргийн Засаг дарга нарт монгол гэрийн ханын хэмжээ, одоо байгаа дулаалгын төрөл, дулаалах шаардлагатай эсэх, байшингийн ханын талбайн хэмжээ, одоо байгаа цонх, дээврийн дулаалгын төрөл зэрэг нийт 6 төрлийн дэлгэрэнгүй судалгааг ирүүлэх албан бичиг хүргүүлж, нийт 17067 гэр сууц, 22388 байшин буюу нийт 39455 өрхийг дулаалах судалгааг авч нэгтгэсэн. Уг ажлын хүрээнд дулаалах 17067 монгол гэртэй өрх, 22388 байшинтай өрх, байшингийн ханын хэмжээ/мкв/-аар 2.103.77.4, дээврийн хэмжээ/мкв/-аар 1.343.311.1 хэмжээгээр "XPS дулаалгын	Хэрэгжсэн	-	-

				хөөс"-өөр байшингийн хана, дээврийн хөндийг шүршдэг хөөсөөр тус тус дулаалах ажлын тооцоо судалгааг хийж, үе шаттайгаар хэрэгжүүлж байна 2025.02.24-03.26-ны өдрийг дуустал 5 өрхөд Heat pump цахилгаан халаагуурыг туршилтаар суурилуулах, Динамик тауэр ХХК Польш улсын Авента компанийн үйлдвэрлэсэн эрчим хүчний хэмнэлттэй агаар сэлгэх тоног төхөөрөмжийг ХУД 20 дугаар хорооны Орхон Хасү өрөнхий боловсролын сургуульд суурилуулан харьцуулсан байдлаар дотоод орчны агаар дахь нийтлэг бохирдуулагч бодисын агууламжийг тодорхойлох нийт 1 сургууль, 14 өрхөд туршилт судалгааны ажлыг хийж, хэмжилт мэдээллийг гаргаж ажилласан.			
128	241	Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-03-19 Дугаар 2025_133	3.6.олон нийтэд ойлгомжтой,хүртээмжтэй байдлаар цахилгаан, хийнсууцжуулалтын яамтай хамтран Агаарын халаагуурыг ашиглах аюулгүй байдлынчанарыг сайжруулах бүсийн айл өрхүүдийг зааварчилгааг сурталчлан таниулахцахилгаан болон бүх төрлийн хийн ажлыг зохион байгуулж, тээвэрлэлт,халаагуурт үе шаттай шилжүүлэхтэй хадгалалтын аюулгүй ажиллагааныхолбоотойгоор ногоон бүсэд хамаарах горим, стандартыг мөрдүүлэх арга51,080 айл өрхийн гэр, байшингийн хэмжээ авч ажиллахыг Монгол Улсындулаалга ажлын хүрээнд "Дулаан байшин" Шадар сайд С.Амарсайхан, Аж үйлдвэр,амины орон сууцны нээлттэй өдөрлөгийг эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Зам,2025 оны 05 дугаар сарын 4-7-ны хооронд тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, БайгальЖанжин Д.Сүхбаатарын талбайд зохион орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдбайгуулж, нийт 12,000 гаруй иргэд олон С.Одонтуяа, Батлан хамгаалахын сайднийтэд дулаалгын талаар танилцуулга С.Бямбацогт, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Нийслэлийн Засаг дарга	Тус газар нь Хот байгуулалт, барилга, орон	Хэрэгжсэн	-	-

			бөгөөд Улаанбаатар хотын Захирагч мэдээлэл, 12000 гаруй ширхэг гарын авлага хүргэн ажилласан болно. Х.Нямбаатар нарт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай А/482 дугаар захирамжийн хүрээнд "Гэр, байшингийн дулаалгын дэлгэрэнгүй судалгааг хийж гүйцэтгэх албан хаагчдыг чадавхжуулах" сэдэвт сургалтыг 2025.04.21-23-ны өдрийг хүртэл 3 хоногийн хугацаанд Баянгол, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар нийт 5 дүүргийн 35 хороо, 474 хэсгийн ахлагч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах сургалтыг зохион байгуулж ажилласан. Мөн уг захирамжийн хүрээнд ногоон бүсэд байрлалтай СХД, БЗД, ЧД, СБД, БГД нийт 5 дүүргийн Засаг дарга нарт монгол гэрийн ханын хэмжээ, одоо байгаа дулаалгын төрөл, дулаалах шаардлагатай эсэх, байшингийн ханын талбайн хэмжээ, одоо байгаа цонх, дээврийн дулаалгын төрөл зэрэг нийт 6 төрлийн дэлгэрэнгүй судалгааг ирүүлэх албан бичиг хүргүүлж, нийт 17067 гэр сууц, 22388 байшин буюу нийт 39455 өрхийг дулаалах судалгааг авч нэгтгэсэн. Уг ажлын хүрээнд 17067 гэр, 22388 байшин, байшингийн ханын хэмжээ/мкв/-аар 2.103.77.4, дээврийн хэмжээ/мкв/-аар 1.343.311.1 хэмжээгээр "XPS дулаалгын хөөс"-өөр байшингийн хана, дээврийн хөндийг шүршдэг хөөсөөр тус тус дулаалах ажлын тооцоо судалгааг хийж, үе шаттайгаар хэрэгжүүлж байна.			
--	--	--	--	--	--	--

	243	3.9. 3.9.хийн түлшний болон цахилгаан халаагуурт 2025 оноос эхлэн шилжиж байгаатай холбогдуулан стандарт, норм дүрмийг шинээр баталж, мөрдүүлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх яаралтай хэрэгцээ, шаардлагыг үндэслэн худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай зохион байгуулж ажиллахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт,	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журмын төслийг боловсруулан, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2025 оны 03 сарын 24-ний өдөр хэлэлцүүлж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025.04.23-ны өдрийн 01/1937 дугаартай журмын төсөлд санал хүргүүлэх тухай албан бичгийн дагуу Журмын төслийн 2.1.1, 2.1.9, 3.1.2, 3.1.4 зэрэг заалтад тус тус саналыг тусган хамтарсан тушаал, захирамжийг баталгаажуулахаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2025 оны 05 сарын 22-ны өдөр 01/3332 тоот албан бичгээр хүргүүлсэн. Уг журмын хүрээнд агаарын чанарыг сайжруулах ногоон бүсэд хамрагдах 103090 өрхийг 2025-2028 онд бүх төрлийн хий, цахилгаан, сэргээгдэх эрчим хүч, бусад эх үүсвэрт үе шаттайгаар шилжүүлэх, үүнээс 2025-2026 онд хийн түлшинд 33794 өрх, цахилгаан халаагуурт 17286 нийт 51080 өрхийг хий болон цахилгаан халаагуурт шилжүүлэхээр бэлтгэж байна.	Хэрэгжсэн	-	-
	244	3.10.энэ тогтоолын 1-д заасан үйл ажиллагааны хүрээнд Засгийн газрын гишүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нутгийн захиргааны болон холбогдох мэргэжлийн байгууллагын үүргийг хуваарилан, удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 133 дугаар тогтоолын хүрээнд "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах ногоон бүсийн 2025-2026 онд цахилгаан болон бүх төрлийн хийн халаагуурт шилжүүлэх айл өрхийн байршлыг тогтоох төслийг боловсруулан 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн	Хэрэгжсэн	-	-

		бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар.	01/367 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газарт хүргүүлсний дагуу, 2025.06.10-ний өдрийн 01/3788 дугаартай албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх тухай хүсэлтийг хүргүүлээд байна.			
246	5. 5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д заасан татварын хөнгөлөлтөд агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр, амины орон сууцыг дулаалах, хийн түлшний болон цахилгаан халаагуур, бусад дэвшилтэт технологийн шийдлийг нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон санхүүгийн дэмжлэг, хандивыг хамааруулах талаар дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлан таниулах, уриалах арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт даалгасугай.	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай А/482 дугаар захирамжийн хүрээнд "Гэр, байшингийн дулаалгын дэлгэрэнгүй судалгааг хийж гүйцэтгэх албан хаагчдыг чадавхжуулах" сэдэвт сургалтыг 2025.04.21-23-ны өдрийг хүртэл 3 хоногийн хугацаанд Баянгол, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар нийт 5 дүүргийн 35 хороо, 474 хэсгийн ахлагч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах сургалтыг зохион байгуулж ажилласан. Мөн уг захирамжийн хүрээнд ногоон бүсэд байрлалтай СХД, БЗД, ЧД, СБД, БГД нийт 5 дүүргийн Засаг дарга нарт монгол гэрийн ханын хэмжээ, одоо байгаа дулаалгын төрөл, дулаалах шаардлагатай эсэх, байшингийн ханын талбайн хэмжээ, одоо байгаа цонх, дээврийн дулаалгын төрөл зэрэг нийт 6 төрлийн дэлгэрэнгүй судалгааг ирүүлэх албан бичиг хүргүүлж, нийт 17067 гэр сууц, 22388 байшин буюу нийт 39455 өрхийг дулаалах судалгааг авч нэгтгэсэн.	Уг ажлын хүрээнд 17067 гэр, 22388 байшин, байшингийн ханын хэмжээ/мкв/-аар 2.103.77.4, дээврийн хэмжээ/мкв/-аар 1.343.311.1 хэмжээгээр "XPS дулаалгын	Хэрэгжсэн	-	-

				хөөс"-өөр байшингийн хана, дээврийн хөндийг шүршдэг хөөсөөр тус тус дулаалах ажлын тооцоо судалгааг хийж, үе шаттайгаар хэрэгжүүлж байна.			
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
139	258	2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр 3 дугаар тэмдэглэл 2022-01-12 Дугаар 2022_3	ХХҮИ.4.1. Сайжруулсан түлшний түүхий эд болох мидлинг болон түлшний чанарт шалгалт хийж, лабораторийн дүгнэлт гаргуулах, түлшний стандартыг хянах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулж, стандартын зөвлөлөөр хэлэлцүүлж, дүнг 2022 оны 1 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар нарт;	“Тавантолгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний чанар стандартын шаардлага хангаж буй байдалд тогтмол хяналт шалгалтыг хийж байна. 2025 оны 01 дүгээр сарын 03-аас 06 дугаар сарын 20-ны байдлаар Төв, Зүүн Баруун бүсийн үйлдвэрийн үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлшний 13, мидлингийн 5, барьцалдуулагчийн 2 дээж нийт 20 дээжид Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газрын төв лаборатори, Геологийн судалгаа шинжилгээний төв ТӨҮГ, Хими, химийн технологийн хүрээлэнгийн итгэмжлэгдсэн лабораторид тус тус техникийн шинжилгээг хамруулан улсын байцаагчийн 7 дүгнэлт гаргасан байна. Тавантолгой түлш ХХК-ний бүтээгдэхүүн болон барьцалдуулагч өөрчилсөн 18 шахмал түлшинд хаягдал утааны хийн хэмжилт хийж ажилласан. Хаягдал утааны хэмжилтийн өгөгдлүүдийг Монгол Улсын MNS5216:2016 стандартад заасан үзүүлэлттэй тус тус харьцуулан боловсруулахад стандартын шаардлага хангасан 15 хангаагүй 3 түлш байна.	Хэрэгжсэн	-	-

149	269	2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33	Ү.2. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан холбогдох албан тушаалтанд даалгав: 2.1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэд, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж ажиллахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэхэд, сайжруулсан шахмал түлшний түгээлт, хангалтыг хариуцан ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт;	Сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлт: НЗД-ын 2024 оны "Эрх шилжүүлэх тухай" А/118 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 2024-2025 онд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх 30 багц ажлыг худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, 29 багцад 27 тээврийн компанийг хуулийн хүрээнд сонгон шалгаруулж, "Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гэрээ"-г байгуулсан. Уг ажлын хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийг дуустал хугацаанд 27 тээврийн компани нь зүүн болон баруун бүсийн үйлдвэрээс эцсийн борлуулалтын цэг, агуулахад нийт 542,155 тонн сайжруулсан шахмал түлшийг тасралтгүй тээвэрлэн 9,588,593,215 төгрөгийн санхүүжилт олгосон.	Хэрэгжсэн	-	-
150	270	2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2022-08-03 Дугаар 2022_39	ХҮИИ.3.2.3. Сайжруулсан шахмал түлшний нийт нөөц, борлуулалтын цэгүүдэд байгаа түлшний үлдэгдэл болон борлуулалтын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, хэрэглэгчдэд хүндрэлгүй, шуурхай хүргэх бэлтгэл ажлыг хангах, эрчим хүчний үнэ тарифыг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар нарт;	Сайжруулсан шахмал түлшний нөөцлөлт: Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Эрх шилжүүлэх тухай" А/121 дүгээр захирамжын хүрээнд халаалтын улиралд гэр хорооллын айл өрхийн хэрэгцээнд зориулж 100 мянган тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлж ажиллахыг үүрэг болгосоны дагуу нийслэлийн 4, түрээсийн 44 агуулах сонгон шалгаруулж, "Сайжруулсан шахмал түлш нөөцлөх, гурвалсан гэрээ"-г байгуулан ажилласан. 2025 оны хагас	Хэрэгжсэн	-	-

			жилийн байдлаар 302 тн сайжруулсан шахмал түлшний үлдэгдэл нөөцтэй байна. Сайжруулсан шахмал түлшний борлуулалт: Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд 2025 оны халаалтын улиралд нийт сайжруулсан шахмал түлш борлуулагч 541 борлуулалтын цэгт сайжруулсан шахмал түлшийг ханган нийлүүлж, борлуулалтын цэгийн өдөр тутмын түлшний татан авалт, борлуулалтад хяналт тавин борлуулалтын урамшуулалын санхүүжилтийг олгож ажилласан. НЗД-ын 2025 оны "Борлуулалтын урамшуулал олгох тухай" А/142 дугаар захирамжийн хүрээнд 7 дүүргийн хэмжээнд 541 борлуулалтын цэг ажиллаж 3,312,878,800 төгрөгийн борлуулалтын урамшуулал олгосон.				
158	288	2023 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр 1 дүгээр тэмдэглэл 2023-01-04 Дугаар 2023_1	XVI.2.. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдэж байгаа ажлын явцын талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа ажлаа эрчимжүүлэх, шахмал түлшний чанарыг сайжруулах, агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг уялдуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ,	Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, тухайн бүсэд мөрдөх журмыг батлах ажлын хүрээнд "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журмын" төслийг боловсруулан, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2025 оны 03 сарын 24-ний өдөр хэлэлцүүлж, МУБОУАӨ-н яамны 2025.04.23-ний өдрийн 01/1937 дугаартай журмын төсөлд санал хүргүүлэх тухай албан бичгийн дагуу Журмын төслийн 2.1.1, 2.1.9, 3.1.2, 3.1.4 зэрэг заалтад тус тус саналыг тусган хамтарсан тушаал, захирамжийг баталгаажуулахаар Байгаль	Хэрэгжсэн	-	-

			Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав.	орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2025 оны 05 сарын 22-ны өдөр 01/3332 тоот албан бичгээр хүргүүлж, батлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Яндангүй бүсийн хилийн заагийг тодорхойлж, бүсэд мөрдөх журмын төслийг батлагаажуулсны дараа хэрэгжилтийг хангаж ажиллахаар бэлтгэж байна. "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд цахилгаан халаагуур болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг төхөөрөмж суурилуулах, тэдгээрийн хэрэглээнд үнийн урамшуулал олгох журам"-ын төслийг боловсруулан НИТХ-ийн 2025 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийн 25/59 дугаар тогтоолоор баталуулсан болно. Журмын хэрэгжилтийн хүрээнд ногоон бүсэд 170 мянга гаруй өрх хамрагдаж байгаа бөгөөд 2025 онд 51,080 өрхийг цахилгаан болон бүх төрлийн хийн түлшний хэрэглээнд шилжүүлэн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг нэг удаа үнэ төлбөргүй суурилуулж, халаалтын улиралд хэрэглээнд нь дараах байдлаар үнийн урамшуулал олгохоор төлөвлөөд байна. Агаарын бохирдлыг бууруулах агаар дахь PM2.5, PM10 тоосонцрын хэмжээг бууруулах ажлын хүрээнд Хүйтний улирал буюу 2025.10.01-2026.04.01 хүртлэх Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг өмнөх онуудын мөн үеийн сарын дундаж агууламжтай харьцуулахад			
--	--	--	---	---	--	--	--

				PM2.5 тоосонцор нь 53 мкг/м3-ээр буюу 16%-иар бага, азотын давхар исэл (NO2) нь 47 мкг/м3-ээр буюу 11%-иар бага, хүхэрлэг хий (SO2) нь 68 мкг/м3-ээр буюу 16%-иар тус тус бага, PM10 тоосонцор нь 106 мкг/м3-ээр буюу 5%-иар их үзүүлэлттэй байна. Мөн Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчийн өгсөн үүрэг даалгаврын дагуу 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 26-ний өдрийг дуустал 5 өрхөд Heat pump цахилгаан халаагуур нийт 1 сургууль, 14 өрхөд туршилтаар суурилуулан хэмжилт мэдээллийг гаргаж, ажилласан.			
196	363	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэл 2025-01-18 Дугаар 2024_44	44.22.1.2. Бүх төрлийн хийн түлшний халаалт бүхий өрхүүдэд хийн түлшний үнийн урамшуулал олгох хувь, урамшууллын хэмжээг тогтоосон журмын төсөл, "Яндангүй бүс"-д бүх төрлийн хатуу түлш хэрэглэхийг хориглосон шийдвэрийн төслийг тус тус боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;	"Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд цахилгаан халаагуур болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг төхөөрөмж суурилуулах, тэдгээрийн хэрэглээнд үнийн урамшуулал олгох журам"-ын төслийг боловсруулан НИТХ-ийн 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 25/59 дугаар тогтоолоор батлуулсан. Журмын хэрэгжилтийн хүрээнд ногоон бүсэд хамаарах 103,090 өрхөөс, 2025 онд 51,080 өрхийг цахилгаан болон бүх төрлийн хийн түлшний хэрэглээнд шилжүүлэн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг нэг удаа үнэ төлбөргүй суурилуулж, халаалтын улиралд буюу 2025.09.15-2026.05.15-ны өдрийг дуустал хэрэглээнд нь 25,000-200,000 буюу нийт 900,000 төгрөгийн урамшууллыг олгохоор зохицуулсан.	Хэрэгжсэн	-	-

			Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хянал шалгалт зохион байгуулах тухай" А/33 дугаар захирамжийн хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд агаарын бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулсан. Нийслэлийн гэр хорооллын бүсэд 170,855 зуух тоологдсон бөгөөд 103,090 өрхийг ногоон бүсэд, 67,765 өрхийг шар бүсэд тус бүр хамааруулсан бөгөөд бүсийн хилийн заагийг тодорхойлж, зурагжуулсан. "Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журам"- "Яндангүй бүс"-д бүх төрлийн хатуу түлш хэрэглэхийг хориглож, баталгаажуулж байгаа болно.			
364	44.22.1.4. Хийн түлшний халаалтад шилжүүлэхээр төлөвлөсөн бүсийн өрхүүдэд хийн халаалтын тоног төхөөрөмжийг ногоон зээлээр авах боломжийг бүрдүүлж, шаардагдах дэмжлэгийг судлан холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;	Хийн түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд цахилгаан халаагуур болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг төхөөрөмж суурилуулах, тэдгээрийн хэрэглээнд үнийн урамшуулал олгох журам"-ын төслийг боловсруулан НИТХ-ийн 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 25/59 дугаар тогтоолоор батлуулсан. Журмын хэрэгжилтийн хүрээнд 2025 онд 51,080 өрхийг цахилгаан болон бүх төрлийн хийн түлшний хэрэглээнд шилжүүлэн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг нэг удаа үнэ төлбөргүй суурилуулж, халаалтын улиралд	Хэрэгжсэн	-	-	

				2025.09.15-2026.05.15-ны өдрийг дуустал хэрэглээнд нь 25,000-200,000 буюу нийт 900,000 төгрөгийн урамшууллыг олгохоор зохицуулсан.			
	365		44.22.1.5. Яндангүй бүсийн зураглал, хамрагдах өрхийн судалгааг гаргаж, яндангүй бүс тогтоож байгаа талаар олон нийтэд зарлан мэдээлэх, уг бүсэд хамрагдах өрхүүдийг эрчим хүчний хэмнэлт бүхий дулаан алдагдал багатай орон сууц, монгол гэрийн иж бүрэн дулаалга, хийн болон цахилгаан халаагуур, стандартын шаардлага хангасан давхар шаталтат зуух зэрэг ногоон зээлийн бүтээгдэхүүнээр хангах шийдвэрийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;	Нийслэлийн гэр хорооллын бүсэд 170,855 зуух тоологдсон бөгөөд 103,090 өрхийг ногоон бүсэд, 67,765 өрхийг шар бүсэд тус бүр хамааруулсан бөгөөд бүсийн хилийн заагийг тодорхойлж, зурагжуулсан. "Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журам"-аар "Яндангүй бүс"-д бүх төрлийн хатуу түлш хэрэглэхийг хориглож, баталгаажуулж байгаа болно. Хийн түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд цахилгаан халаагуур болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг төхөөрөмж суурилуулах, тэдгээрийн хэрэглээнд үнийн урамшуулал олгох журам"-ын төслийг боловсруулан НИТХ-ийн 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 25/59 дугаар тогтоолоор батлуулсан. Журмын хэрэгжилтийн хүрээнд 2025 онд 51,080 өрхийг цахилгаан болон бүх төрлийн хийн түлшний хэрэглээнд шилжүүлэн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг нэг удаа үнэ төлбөргүй суурилуулж, халаалтын улиралд 2025.09.15-2026.05.15-ны өдрийг дуустал хэрэглээнд нь 25,000-200,000 буюу нийт	Хэрэгжсэн	-	-

			900,000 төгрөгийн урамшууллыг олгохоор зохицуулсан.			
366		44.22.1.6. Агаарын чанарын бүсэд хууль бусаар түүхий нүүрс нэвтрүүлж, ашиглаж байгаа эсэхэд тавих хяналтыг чангатгаж, зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;	Засгийн Газрын 2018 оны 62-р тогтоол, агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Өлзийт, Зөрлөг, Гродок, Таван толгой, Гүнт, Эмээлт, Баруун Туруун дах авто тээврийн нийт 7 шалган нэвтрүүлэх товчоодод Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газраас нийт 28 эргүүл хяналтын ажилтан 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажилласан. Тайлант хугацаанд 28645 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийснээс агаарын чанарыг сайжруулах бүс рүү нийт 79748 тн 463кг түүхий нүүрс бүртгэн нэвтрүүлсэн байна. Үүнээс 49291 тн 622 кг түүхий нүүрс нийслэл хотоор дамжин өнгөрч, 15 удаа сайжруулсан шахмал түлш гаргахыг завдсан зөрчлийг хяналт шалгалтаар илрүүлэн, холбогдох байгууллагад шилжүүлэн ажилласан.	Хэрэгжсэн	-	-
367		44.22.1.7. "Тавантолгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний чанар, аюулгүй байдлын стандарт, үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, үр дүнг тухай бүр танилцуулахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Нийслэлийн Засаг дарга	"Таван толгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний чанар стандартын шаардлага хангаж буй байдалд тогтмол хяналт шалгалтыг хийж байна. 2025 оны 01 дүгээр сарын 03-аас 06 дугаар сарын 20-ны байдлаар Төв, Зүүн Баруун бүсийн үйлдвэрийн үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлшний 13, мидлингийн 5, барьцалдуулагчийн 2 дээж нийт 20 дээжид Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газрын төв лаборатори, Геологийн	Хэрэгжсэн	-	-

			бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;	судалгаа шинжилгээний төв ТӨҮГ, Хими, химийн технологийн хүрээлэнгийн итгэмжлэгдсэн лабораторид тус тус техникийн шинжилгээг хамруулан улсын байцаагчийн 7 дүгнэлт гаргасан байна.			
204	404	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-03-26 Дугаар 2025_14	14.16.4.1. Нийслэл Улаанбаатар хотын агаар дахь үнэрт нүүрстөрөгчийг тодорхойлох, утааны хийн агууламжийг тогтмол хэмжих болон цахим хяналтын системийг нэвтрүүлэхэд шаардлагатай багаж, дагалдах тоног төхөөрөмж, тэдгээрийг худалдан авах санхүүжилтийн эх үүсвэрийн талаар судалж, санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;	Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25 -ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/547 тоот захирамжаар "Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмж" худалдан авах 1,096.0 сая төгрөгийн санхүүжилттэй 4 төсөл арга хэмжээний 3 ажлыг Худалдан авах ажиллагааны газар, 1 ажлыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх зохион байгуулж байна. Худалдан авах ажиллагааны газар 3 багц ажлын хүрээнд тендер сонгон шалгаруулах зарыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд (www.tender.gov.mn) байршуулж тендерийн нээлтийг 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдөр нээж үнэлгээний хорооны хурлаар хэлэлцсэн. Багц-1: Дуу чимээ, үнэрийн хэмжээг тодорхойлох багаж тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг дахин зарлаж 2025 оны 06 сарын 23-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нээсэн. Багц-2: Автомашины хаягдал утааны хийн хэмжилт хийх багаж тоног төхөөрөмж	Хэрэгжсэн	-	-

			нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон. Багц-3: Орчны бохирдлыг хэмжих суурин төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон. Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газар 4 дэх заалтын хүрээнд "Тоног төхөөрөмжийн тохируулга хийх стандарт хий нийлүүлэх" нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон.		
Хэрэгжилтийн дүн				100	

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.МӨНХБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

АРИУНТУНГАЛАГ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ХАМТЫН
АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Г.ДӨЛГӨӨН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ТӨВӨЛЛӨГӨӨ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ө.МӨНГӨН-ЭРДЭНЭ